

АГААРЫН ТЭЭВРИЙН ДААТГАЛ

Монгол Улсын агаарын тээврийн үйл ажиллагааны үед осол, зөрчлөөс шалтгаалан гарч болзошгүй хохирлыг барагдуулах талаар Монгол Улсын хуулиудад дараах байдлаар заасан байна.

Монгол Улсын Үндсэн хуульд:

Аравдугаар зүйл.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.
3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

1999 оны Иргэний нисэхийн тухай хуульд:

2 дугаар зүйл.Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж

- 2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

30 дугаар зүйл.Олон улсын нислэг үйлдэх зөвшөөрөл, даатгал

- 30.2. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх гадаад улсын агаарын хөлөг нь **гуравдагч этгээдэд учирч болзошгүй хохирлыг хариуцах баталгаа бүхий даатгалтай байна.** (нэг ослын үед гуравдагч этгээдийн даатгалын нөхөн олговор 1-5 сая \$ байдаг бол, харин зорчигчийн даатгалын нийт нөхөн олговор 1 тэрбум \$ хүрдэг)

36 дугаар зүйл.Зорчигчийн даатгал

- 36.1. Иргэний агаарын хөлгөөр **зорчигч нь өөрийн амь насыг даатгуулах үүрэгтэй.** (Буруу заалт, хүчингүй болгох)

37 дугаар зүйл.Иргэний агаарын хөлгийн багийн гишүүдийн даатгал

- 37.1.Иргэний агаарын хөлгийн багийн гишүүдийг албан үүргээ гүйцэтгэж байгаа үед тэдний амь нас, **эрүүл мэндийг** тэдгээрийг ажиллуулагч аж ахуйн нэгж, байгууллага даатгуулах үүрэгтэй.

38 дугаар зүйл.Тээвэрлэгчийн хариуцлагын даатгал

- 38.1. Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлгөөр зорчигчийн амь нас, эрүүл мэнд болон гуравдагч этгээдэд учруулсан хохирол, түүнчлэн зорчигчийн ачаа, тээш, шуудан алдагдах, дутах буюу гэмтсэн тохиолдолд нөхөн олговор олгох зориулалттай **хариуцлагын даатгалд** даатгуулна. (даатгалын горим нь тодорхой бус байгаа тул “Монреалийн конвенцийн шаардлагад нийцсэн даатгалтай байх” гэж залруулах)

Монгол Улс 2004 онд “Олон улсын агаарын тээвэрт хамаарах даатгалын зарим журмыг нэг мөр болгох тухай” 1999 оны Монреалийн Конвенцид нэгдэн орсноор энэ конвенци нь Монгол Улсын хууль болсон.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

“ОЛОН УЛСЫН АГААРЫН ТЭЭВЭРТ ХАМААРАХ ЗАРИМ

ЖУРМЫГ НЭГ МӨР БОЛГОХ ТУХАЙ КОНВЕНЦИ”-Д

НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монреаль хотноо 1999 оны 5 дугаар сарын 28-ны өдөр баталсан “Олон улсын агаарын тээвэрт хамаарах зарим журмыг нэг мөр болгох тухай Конвенци”-д Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

Энэ хуулийн дагуу Монгол Улс олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаанд Монреалийн Конвенцийн дагуу дараах шаардлагыг хангасан хууль, эрх зүйн зохицуулалтыг хийх үүрэг хүлээсэн.

1999 оны Монреалийн Конвенци	Тайлбар
<p>Article 21 - Compensation in Case of Death or Injury of Passengers</p> <p>1. For damages arising under paragraph 1 of Article 17 not exceeding 128,821 Special Drawing Rights for each passenger, the carrier shall not be able to exclude or limit its liability.</p> <p>2. The carrier shall not be liable for damages arising under paragraph 1 of Article 17 to the extent that they exceed for each passenger 128,821 Special Drawing Rights if the carrier proves that:</p> <p>(a) such damage was not due to the negligence or other wrongful act or omission of the carrier or its servants or agents; or</p> <p>(b) such damage was solely due to the negligence or other wrongful act or omission of a third party.</p>	<p>- тээвэрлэлтийн үед зорчигч амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтэл авсан тохиолдолд: 128,821 SDR / 180,349 \$ / 514 сая ₮</p> <p><u>1SDR=\$1.4=3990₮,</u> <u>1USD=2850₮</u> <u>(2021 оны 12 сарын байдлаар)</u></p>
<p>Article 22 - Limits of Liability in Relation to Delay, Baggage and Cargo</p> <p>1. In the case of damage caused by delay as specified in Article 19 in the carriage of persons, the liability of the carrier for each passenger is limited to 5,346 Special Drawing Rights.</p> <p>2. In the carriage of baggage, the liability of the carrier in the case of destruction, loss, damage or delay is limited to 1,288 Special Drawing Rights for each passenger unless the passenger has made, at the time when the checked baggage was handed over to the carrier, a special declaration of interest in delivery at destination and has paid a supplementary sum if the case so requires. In that case the carrier will be liable to pay a sum not exceeding the declared sum, unless it proves that the sum is greater than the passenger's actual interest in delivery at destination.</p> <p>3. In the carriage of cargo, the liability of the carrier in the case of destruction, loss, damage or delay is limited to a sum of 22 Special Drawing Rights per kilogramme, unless the consignor has made, at the time when the package was handed over to the carrier, a special declaration of interest in delivery at destination and has paid a supplementary sum if the case so requires. In that case the carrier will be liable to pay a sum not exceeding the declared sum, unless it proves that the sum is greater than the consignor's actual interest in delivery at destination.</p>	<p>- тусгайлан мэдүүлсэн зорчигчийн ачаа, тээш алдагдсан, гэмтсэн, саатсан тохиолдолд хохирлын дээд хязгаар нь: 5,346 SDR / 7,484 \$ / 21.3 сая ₮</p> <p>- тээш алдагдсан, гэмтсэн, саатсан тохиолдолд зорчигч нэг бүрд: 1,288 SDR / 1,803 \$ / 5.1 сая ₮</p> <p>- ачаа алдагдсан, гэмтсэн, саатсан тохиолдолд тээвэрлүүлэхээр мэдүүлсэн ачааны килограмм тутамд: 22 SDR / 30.8 \$ / 87,800₮</p>

Мөн Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан Нислэгийн аюулгүй байдлын загвар хуульд гишүүн орнуудыг Иргэний нисэхийн тухай хуульдаа даатгалын талаар дараах заалтуудыг оруулахыг шаарддаг:

Model Civil Aviation Safety Act:

901. ЭДИЙН ЗАСГИЙН ЗӨВШӨӨРӨЛ

(f) **ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ.** Сайдын баталсан даатгалын бодлого, эсхүл өөрийн даатгалын төлөвлөгөөг хэрэгжүүлэх сайдын гаргасан тушаал болон журмыг биелүүлсэн хүсэлт гаргагчид сайд гэрчилгээ олгоно. Даатгалын бодлого, эсхүл төлөвлөгөөний дагуу олгох гэрчилгээнд заасан **үйл ажиллагаа, эсхүл агаарын хөлөг, нисэхийн бүтээгдэхүүний техник үйлчилгээнээс үүдэлтэй хүний амь нас хохирсон, бэртэж гэмтсэн, эсхүл эд хөрөнгө алдагдаж үрэгдсэн тохиолдолд төлөх нөхөн олговор нь хохирлыг барагдуулахад хүрэлцээтэй**, даатгуулсан хэмжээнээс ихгүй байх ёстой. Агаарын тээвэрлэгч зөвхөн энэ заалтыг биелүүлсэн нөхцөлд түүний гэрчилгээ хүчинтэй хэвээр байна.

902. ГАДААДЫН АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

(e) **ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ.** Сайдын баталсан даатгалын бодлого, эсхүл өөрийн даатгалын төлөвлөгөөг хэрэгжүүлэх сайдын гаргасан тушаал болон журмыг биелүүлсэн хүсэлт гаргагчид сайд зөвшөөрөл олгоно. Даатгалын бодлого, эсхүл төлөвлөгөөний дагуу олгох зөвшөөрөлд заасан **үйл ажиллагаа, эсхүл агаарын хөлөг, нисэхийн бүтээгдэхүүний техник үйлчилгээнээс үүдэлтэй хүний амь нас хохирсон, бэртэж гэмтсэн, эсхүл эд хөрөнгө алдагдаж үрэгдсэн тохиолдолд төлөх нөхөн олговор нь хохирлыг барагдуулахад хүрэлцээтэй**, даатгуулсан хэмжээнээс ихгүй байх ёстой. Гадаадын агаарын тээвэрлэгч энэ заалтыг биелүүлсэн нөхцөлд түүний зөвшөөрөл хүчинтэй хэвээр байна.

Европын холбооны улсын Иргэний нисэхийн удирдах газар (EASA) нь “Олон улсын агаарын тээвэрт хамаарах зарим журмыг нэг мөр болгох тухай” Монреалийн конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор “**REGULATION (EC) No 2027/97**” бичиг баримтыг боловсруулан гаргасан бөгөөд үүнийг дэлхийн 100 гаруй улс өөрийн даатгалын хууль, эрх зүйн баримт бичигт ашиглаж байна.

Олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаатай холбоотой төрийн даатгалын бодлогыг Олон улсад өргөн хэрэглэж байгаа EASA-ийн гаргасан REGULATION (EC) No 2027/97 баримт бичигт нийцүүлэн дараах байдлаар гаргах шаардлагатай. Үүнд:

- тээвэрлэлтийн үед зорчигч амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтэл авсан тохиолдолд 128,821 SDR / 180,349 \$ / 514 сая ₮
- тусгайлан мэдүүлсэн зорчигчийн ачаа, тээш алдагдсан, гэмтсэн, саатсан тохиолдолд хохирлын дээд хязгаар нь 5,346 SDR / 7,484 \$ / 21.3 сая ₮
- тээш алдагдсан, гэмтсэн, саатсан тохиолдолд зорчигч нэг бүрд 1,288 SDR / 1,803 \$ / 5.1 сая ₮,
- ачаа алдагдсан, гэмтсэн, саатсан тохиолдолд тээвэрлүүлэхээр мэдүүлсэн ачааны килограмм тутамд 22 SDR / 30.8 \$ / 87,800 ₮
- зорчигч нас барсан, эсхүл хүнд гэмтсэн тохиолдолд агаарын тээвэрлэгч нөхөн олговор олгох бөгөөд дээрх хариуцлагын хязгаарын 16,000 SDR (64 сая ₮)-аас багагүй хэмжээний нөхөн олговрыг тухайн амь насаа алдсан ослын хохирогчийг таньж тогтоосноос хойш 15 хоногийн дотор үл маргах журмаар урьдчилан төлөх үүрэгтэй.

Монгол Улсын **орон нутгийн агаарын тээврийн үйл ажиллагаанд** зорчигчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болох хохирлыг барагдуулах зохицуулалт тодорхойгүй байгаа тул төрийн даатгалын бодлогод орон нутгийн агаарын тээврийн үйл ажиллагаанд баримтлах зохистой харьцааг хуульчилж, тодорхой болгох шаардлагатай байна.

Одоогийн байдлаар орон нутгийн тээвэрлэлтэд зорчигчийн өмнө хүлээх тээвэрлэгчийн хариуцлагын даатгалын хязгаарыг ИНД-303.9(б)-д дараах байдлаар тусгасан байна:

- 1/ зорчигч тус бүрт 22 сая төгрөг болон түүнээс дээш; [\(дээд хязгаар нь тодорхойгүй\)](#)
- 2/ зорчигчийн биедээ авч яваа эд зүйлийн хувьд зорчигч тус бүрт 200 000 төгрөг;
- 3/ зорчигчийн тээшний нэг кг тутамд 12 000 төгрөг тус тус байна.

Дээр заасан “22 сая төгрөг”-ийн хэмжээг анх 1999 онд МИАТ ХК-ийн даатгалд ашиглаж байсан бөгөөд ИНД-303-ын зохицуулалт нь хууль, эрх зүйн хувьд хүчгүй, нөхөн олговрын хэмжээ нь одоогийн шаардлагыг хангахгүй байна.

Монреалийн конвенцид нийт 136 улс нэгдэн орсон бөгөөд 70 гаруй улсад агаарын тээврийн үйл ажиллагааг олон улс, орон нутаг гэж ялгалгүйгээр хохирлыг барагдуулах хариуцлагын хэмжээг ижил байхаар тогтоосон байдаг.

Дээрх зохицуулалтыг хийхээс гадна зорчигч амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтэл авсан тохиолдолд агаарын тээвэрлэгч нөхөн олговрын 15-аас багагүй хувийг үл маргах журмаар, тухайн ослын хохирогчийг таньж тогтоосноос хойш 15 хоногийн дотор урьдчилан төлдөг байх шаардлагыг хуульчлах шаардлагатай байна.

ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭНИЙ ТАЛААР

1999 оны Монреалийн Конвенцид тээвэрлэлтийн гэрээний талаар дараах шаардлага тавьдаг:

<p>Chapter 2. Documentation and Duties of the Parties Relating to the Carriage of Passengers, Baggage and Cargo</p> <p>Article 3 - Passengers and Baggage</p> <p>4. The passenger shall be given written notice to the effect that where this Convention is applicable it governs and may limit the liability of carriers in respect of death or injury and for destruction or loss of, or damage to, baggage, and for delay.</p>	<p>Бүлэг 2. Зорчигч, тээш болон ачаа тээвэрлэлтэд талуудын бүрдүүлэх баримт бичиг ба хүлээх үүрэг</p> <p>3 дугаар зүйл. Зорчигч ба тээш</p> <p>4. Зорчигч амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтэл авсан, түүний тээш утсан, алдагдсан, эсхүл гэмтсэн, нислэг саатсан тохиолдолд энэхүү Конвенцийн дагуу агаарын тээвэрлэгчийн хүлээх хариуцлагын хязгаарыг тодорхойлсон мэдэгдлийг зорчигчид бичгээр өгдөг байх.</p>
---	--

Монреалийн Конвенцийн дээрх заалтыг ИНД-329 “Тээвэрлэлтийн гэрээ”-нд дараах байдлаар тодорхой зааж оруулсан боловч энэ дүрмийг өнөөдрийн байдлаар Монгол Улсад мөрдүүлж чадахгүй байна:

<p>329.9 Тээвэрлэгчийн үүрэг</p> <p>(а) Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн гэрээг төлөөлөх баримт болох тийз болон ачааны дагавар бичигт тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийг тусгасан байна. Хэрэв гэрээний нөхцөлийг бүрэн тусгаагүй бол энэ дүрэмд шаардсаны дагуу, нэмэлт мэдээллээр зорчигчдыг хангах үүрэгтэй.</p> <p>(б) Тээвэрлэгч нь, өөрийн тээвэрлэлтийн нөхцөлийн талаарх мэдээллийг зорчигчийн хүсэлтээр шуудангаар болон үйлчилгээний бусад хэлбэрээр үнэ төлбөргүй илгээнэ.</p> <p>(в) Тээвэрлэгч нь өөрийн тээвэрлэлтийг борлуулж буй Тийз борлуулах төв болон нисэх буудал дээр тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийн талаарх мэдээллээр зорчигчдыг хангах үүрэгтэй.</p>
--

Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор Монгол Улсын төр даатгалын зохицуулалтыг хууль болон бусад эрх зүйн баримт бичигт тодорхой, зөв тусган, түүнийг чанд даган мөрдүүлж чадвал олныг хамарсан болзошгүй осол, сүйрлийн улмаас үүсэн гарч болох сөрөг үр дагаврыг багасгах боломжийг бүрдүүлнэ.

1998 оны Swissair Flight 111-ийн сүйрлийн нийт нөхөн олговор \$800 сая болсон ба одоогийн даатгалын нөхөн олговрын дээд хэмжээ \$1 тэрбумд хүрч, 2019 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн (9.6 их наяд ₮ / US\$3.5 тэрбум) 1/3-тэй тэнцэж байгаа нь төрөөс даатгалын тууштай бодлого явуулж чадахгүй бол тухайн осол, сүйрлийн хохирлыг олон улсын конвенцийн дагуу төр хариуцах ноцтой байдалд хүргэх аюултай болохыг харуулж байна.

Иш татсан материал:

- Үндсэн хууль;
- Иргэний нисэхийн тухай хууль;
- 1999 оны Монреалийн конвенц;
- Model civil aviation safety act ;
- Regulation (EC) No 2027/97;
- ИНД-303 Агаарын тээвэрлэгчийн даатгал
- ИНД-329 Тээвэрлэлтийн гэрээ.